



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 02 сарын 27 өдөр

Дугаар А/103

Арвайхээр

Ажлын хэсэг байгуулах, журам батлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 дахь заалтын "а" хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1.6 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.3, 36.4, 36.5 дэх заалт, Сангийн сайдын 2012 оны 294 тоот тушаалаар батлагдсан "Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавих шаардлага, шалгуур журам"-ыг тус тус үндэслэн Засгийн газрын 2014 оны "Санхүүгийн алба байгуулах тухай" 326 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумдын Засаг даргын Тамгын газарт болон сумдын бусад төсөвт байгууллагуудад санхүү, нягтлан бодох бүртгэлийн нэгдсэн үйлчилгээ хүргэх, сумын төсөв санхүү, эдийн засаг, хөгжлийн бодлогын төлөвлөлтийг хариуцуулах Засгийн газрын 2014 оны "Санхүүгийн алба байгуулах тухай" 326 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг бэхжүүлэх, нягтлан бодогч нарын үндсэн мэргэжил болон хууль эрх зүйн мэдлэг, мэргэжлийн ур чадварыг үнэлж түвшин тогтоох ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, орон нутгийн төсвийн байгууллагын нягтлан бодогч нарын мэдлэг, мэргэжлийн түвшин тогтоох журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Журмын дагуу нягтлан бодогч нарын үндсэн мэргэжил болон хууль эрх зүйн мэдлэг, мэргэжлийн ур чадварыг үнэлж түвшин тогтоох ажлыг ил тод нээлттэй зохион байгуулж, дүнг Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (И.Доржсүрэн)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2015 оны "Сумын санхүүгийн албаны талаар авах зарим арга хэмжээний тухай" а/154 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.


ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100237

Аймгийн Засаг даргын 2019... оны .03.
дугаар сарын 27 ны өдрийн А/103 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: И.Доржсүрэн (Аймгийн Засаг даргын орлогч)

Нарийн бичгийн дарга: Б.Баяржаргал (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн ерөнхий нягтлан бодогч)

Гишүүд: Д.Нэмэхбаяр (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)

А.Отгонцэцэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)


Э.Бадамгэрэл (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн хүний нөөцийн ахлах мэргэжилтэн)

Л.Хатанбаатар (Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албаны дарга)

М.Эрдэнэчулуун (Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албаны байцаагч)

-оОо-

Аймгийн Засаг даргын 2019..... оны 02
дугаар сарын 27-ны өдрийн 1/102 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт



ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГЫН НЯГТЛАН БОДОГЧ НАРЫН МЭДЛЭГ, МЭРГЭЖЛИЙН ТҮВШИН ТОГТООХ ЖУРАМ

1.1 Сумдын Засаг даргын Тамгын газарт болон сумдад үйл ажиллагаа явуулж байгаа төсвийн байгууллагуудад санхүү, нягтлан бодох бүртгэлийн нэгдсэн үйлчилгээг чанартай хүргэх, сумын төсөв, санхүү, эдийн засаг, хөгжлийн бодлогын төлөвлөлтийг хариуцуулах “Санхүүгийн алба байгуулах тухай” Монгол улсын Засгийн газрын 2014 оны 326 дугаар тогтоолын хэрэгжилт, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг бэхжүүлэх, нягтлан бодогч нарын ур чадварыг үнэлж түвшин тогтооход зорилго оршино.

1.2 Түвшин тогтоох шалгалтыг тухай бүрт нь аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг зохион байгуулна.

Хоёр. Бичиг, баримтын шалгалт

2.1 Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг нь нягтлан бодогч нарын холбогдох бичиг баримтыг хуваарийн дагуу зөвхөн нэг удаа үзэж, шалган дүгнэлт гаргана.

2.2. Баримт бичгэнд тавигдах шаардлага:

2.2.1 Мэргэжлийн үнэмлэх, дипломын үзлэг явуулах. Шалгалтанд орж буй нягтлан бодогч нар нягтлан бодох бүртгэлийн үндэс, санхүүгийн бүртгэл, зардлын бүртгэл, удирдлагын бүртгэл зэрэг хичээлүүдийг тус бүр 2-3 багц цагаас доошгүй судалсан байх шаардлагатай.

2.2.2 Мэргэжил нь нягтлан бодогч, эдийн засагч, санхүүгийн менежмент, бизнесийн удирдлага мэргэжилтэй байж болно.

2.2.3 Зөвхөн бичиг баримтын үзлэгт тэнцсэн нягтлан бодогч дараагийн хоёр шатны шалгалтад орох эрхтэй.

Гурав. Хууль эрх зүйн мэдлэгийг шалгах

3.1 Хууль эрх зүйн мэдлэгийг шалгах сорил нь тест хэлбэртэй байна. Шалгалтад өгөгдсөн тестийг 60 хувиас доошгүй хэмжээнд үнэн зөв бөглөж тэнцсэн байх шаардлагатай.

3.2 Шалгалтын тест нь Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Өмчийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль зэрэг төсөв санхүүгийн холбогдолтой гарсан Монгол улсын Засгийн газрын тогтоолууд, Сангийн сайдын тушаалууд, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй дүрэм, журмын хүрээнд байна.

Дөрөв. Мэргэжлийн болон ур чадварын шалгалт.

4.1 Ур чадварын сорил нь цогц бодлого байна.

4.2 Цогц бодлогын гүйцэтгэл нь 70 хувиас доошгүй үнэн зөв хийгдсэн тохиолдолд тэнцсэнд тооцно.

Тав. Түвшин тогтоох шалгалт явуулах хугацаа, хамрах хүрээ

5.1 Түвшин тогтоох шалгалт жил бүрийн 4 дүгээр сарын сүүлийн 7 хоногийн Баасан, Бямба гарагуудад зохион байгуулагдана.

5.2 Шалгалтанд аймаг, сумын орон нутгийн төсвийн байгууллагын нягтлан бодогч нар заавал хамрагдана.(Мэргэшсэн нягтлан бодогчийн зэрэгтэй хүнд хамаарахгүй)

5.3 Шалгалтад хамрагдаагүй үлдсэн нягтлан бодогч нарыг дараа сард багтааж мэдлэг, мэргэжлийн түвшин тогтоох шалгалтад бүрэн хамруулна.

5.4 Шалгалт тус бүрийн дүнг мөн өдөрт нь багтааж гаргах бөгөөд мэдээллийн самбарт байршуулна.

5.5 Хуулийн болон ур чадварын шалгалтуудын нийлбэр дунджаар 65 хувиас дээш үнэлэгдсэн тохиолдолд түвшин тогтоох шалгалтад тэнцсэнд тооцно.

5.6 Шалгалтад оролцогсод мэргэжлийн үнэмлэх, дипломыг эх хувиар нь авч ирнэ (Мэргэжлийн үнэмлэх, диплом хуулбар хувийг баримт бичгийн үзлэгт хамруулахгүй мөн төрийн сангийн тэтгэлэг болон, зээлээр суралцаж төгссөн дипломын эх хувь байхгүй тохиолдолд Боловсролын яамны лавлагаа авч ирэх).

5.7 Тестийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс болон ажлын хэсэг боловсруулж нууцлалыг хадгална.

Зургаа. Түвшин тогтоох шалгалтын мөрөөр авах арга хэмжээ

6.1 Түвшин тогтоох шалгалтад хангалтгүй үнэлэгдсэн нягтлан бодогч нарыг мэргэжил дээшлүүлэх, давтан сургах, мэргэшүүлэх төлөвлөгөө боловсруулан ажиллана.

6.2 Шалгалтад хангалттай буюу 85 хувиас дээш үнэлгээ авсан нягтлан бодогч нарын ур чадварын нэмэгдлийг 25 хүртэл хувиар 1 жил хүртэл хугацаагаар олгох шийдвэрийг тухайн төсвийн захирагч шийдвэрлэж болно.

6.3 Бичиг баримтын шалгалтад тэнцээгүй нягтлан бодогчдын ажлын байрыг нийтэд нээлттэй зарлаж сонгон шалгаруулалт хийх ажлыг тухайн сумын Засаг даргын Тамгын газар болон шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтан зохион байгуулна.